<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>333,399,719.80</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,935,500.00</b>
210402	Тээвэр, шатахуун	8,075,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,860,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49,375,200.00</b>
210502	Хоол, хүнс	49,375,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>89,619,519.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,088,300.00
210602	Тавилга	3,698,000.00
210604	Урсгал засвар	35,833,219.80
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>166,469,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,469,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,086,753.20</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	5,086,753.20
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,900,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	19,900,000.00
223001	Бусад хөрөнгө	19,900,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>364,386,473.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>364,386,473.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	280,401,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,684,740.00



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын мэдээлэл, харилцаа холбоо, цахим технологи ашиглалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангах, алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, менежментийн шинэлэг арга, хэлбэрийг нэвтрүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2024 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, албан хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрүүл мэндийг хамгаалж, нийгмийн баталгааг хангах, цахим шилжилтэд манлайлж, үйл ажиллагаандаа технологи инновацыг нэвтрүүлж, бүтээлчээр ашиглах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар баталж, мөрдөж эхэлсэн байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,242,903.7 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
<b>Б</b>			
Мөнгөн хөрөнгө	67,653.9	67,206.3	(447.6)
Авлага	1,571.9	15,110.8	13,538.9
Бараа материал	476,845.6	494,979.5	18,133.9
Үндсэн хөрөнгө	7,705,985.2	8,917,663.7	1,211,678.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,252,056.6</b>	<b>9,494,960.3</b>	<b>1,242,903.7</b>
Өр төлбөр	9,810.0	117,792.3	107,982.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,242,246.6	9,377,168.0	1,134,921.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,252,056.6</b>	<b>9,494,960.3</b>	<b>1,242,903.7</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 447.6 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл нь 15,110.8 мянган төгрөг байгаа нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн 3,997.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтөөс үүссэн авлага 5,957.2 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 1,183.4 мянган төгрөг, ажилчдаас авах цалингийн 3,972.5 мянган төгрөгийн авлагыг тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны хувьд тайлант онд төсвийн хөрөнгөөр 301,000.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 32,993.0 мянган төгрөг, Цагдаагийн ерөнхий газраас 11,336.6 мянган төгрөг, урамшуулалд олгосон шатахууны хөнгөлөлт 1,593.9 мянган төгрөг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/212 дугаар тушаалаар малын дансны үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотой 7,348.7 мянган төгрөг, нийт 53,272.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, тус газрын даргын А/53 дугаар тушаалаар 51,377.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 236,635.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаар бараа материалын үлдэгдэл 18,133.9 мянган төгрөгөөр өсжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,211,678.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 101,133.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/154 дүгээр тушаал, аймгийн ИТХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолоор 249,869.9 мянган төгрөгийн автомашин, Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албанаас 367,264.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/18, А34 дүгээр тушаалаар 50,624.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Дотоодын цэргийн штабаас 3,089.1 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 838,975.2 мянган төгрөгийн өргөтгөлийн засвар, тоног төхөөрөмж, Шарын гол сумын ОНХС-аас 4,779.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж зэргийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 29, 39 дүгээр тогтоолоор 105,701.9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/522 дугаар захирамжаар 207,645.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/34 дүгээр тушаалаар 15,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусдад шилжүүлж, 75,709.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 107,892.3 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг дутуу тооцсоноос үүссэн 117,626.3 мянган төгрөг, алба хаагчдаас суутгасан шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн төлбөр 166.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо 9,377,168.0 мянган төгрөг болж, 1,134,921.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 1,512,399.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материалыг орлогоор бүртгэснээс шалтгаалж өссөн тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 8,256,000.7 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 1,064,274.6 мянган төгрөгөөр бууруулан, 7,191,726.1 мянган төгрөгөөр баталсан нь тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 1,525,727.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 8,717,454.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс болон жилийн эцсийн мөнгөн урамшуулалтай холбоотойгоор цалингийн зардлыг 825,433.3 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг 138,874.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг 330,077.3 мянган төгрөг, бусад зардлыг 231,342.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 8,717,454.0 мянган төгрөгийн 98.5 хувь буюу 8,589,054.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 1.5 хувь буюу 128,400.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,589,054.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 137,824.2 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагаанаас 1,681.9 мянган төгрөгийн орлого олж, нийт 8,728,560.1 мянган төгрөг төвлөрснөөс 8,690,401.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 38,158.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлого 11,106.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	<b>70</b>	<b>8,717,454.0</b>	<b>8,690,401.4</b>	<b>(27,052.6)</b>	<b>99.7</b>
	<b>70704- Цагдаа</b>	<b>8,323,417.4</b>	<b>8,296,364.8</b>	<b>(27,052.6)</b>	<b>99.7</b>
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	7,735,503.1	7,708,450.5	(27,052.6)	99.7
2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	581,314.3	581,314.3	-	100.0
3	82315- Байцаан шийтгэх ажиллагаа	6,600.0	6,600.0	-	100.0

	<b>70711- Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах</b>	<b>394,036.6</b>	<b>394,036.6</b>	<b>-</b>	<b>100.0</b>
4	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	394,036.6	394,036.6	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тайлант онд 95,187.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 тендер шалгаруулалтыг хуульд заасны дагуу зохион байгуулж, цахим системд үр дүнг тайлагнасан байна.

Тус газар батлагдсан төсвөөс Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сангийн харилцах дансанд 35,880.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Мөн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 16,985.7 мянган төгрөг төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант онд батлагдсан төсвөөр 275 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 14 орон тоо дутуу ажилласан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 272,410.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас үндэсний их баяр наадмын хамгаалалтын зардалд 6,000.0 мянган төгрөг, Зэвсэг-2024 арга хэмжээний зардалд 1,991.0 мянган төгрөг, Цагдаагийн ерөнхий газрын санхүү ар талын албанаас УИХ болон орон нутгийн сонгуулийн хамгаалалтын зардалд 73,300.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс галт зэвсгийн сургалтад 5,801.7 мянган төгрөг, Чингис мастер кросс хамгаалалтын шатахууны зардалд 4,883.0 мянган төгрөг, нийт 364,386.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулаагүй үлдсэн 5,086.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд харьцуулалтын аргаар шатахуун худалдах, худалдан авах 95,187.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Мөнгөнцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 37/3/596 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 8,786,590.0 мянган төгрөгөөс 1 хувиар букуу 87,865.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд байгууллагын ахмад ажилтнуудын холбооны тэргүүн, гүйцэтгэх захирал нарт ахмадын сангаас 6,930.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *“хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг бүрэн байршуулсан байв.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан 25 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 161 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1,554.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,554.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Төлбөрийн акт	1	1,554.1	1	1,554.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1,554.1</b>	<b>2</b>	<b>1,554.1</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/147 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 947 "Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ"-ийн 947.6.2-ын дагуу Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын даргын 2024 оны Б/42 дугаар тушаалаар тус байгууллагын ахмад ажилтнуудын холбооны тэргүүн, гүйцэтгэх захирал нарт 6,930.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 05/408 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сахилгын шийтгэлтэй 7 албан хаагчид 2,380.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг газрын даргын 2024 оны Б/111 дүгээр тушаалаар олгосон байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,236.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Шатахуун худалдах, худалдан авах гэрээнд заасанд 1,593.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийн урамшууллыг бүртгэлд тусгаагүй нь УСНББОУС-12 "Бараа материал", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгүүлж залруулав.
- Олон нийтийн цагдаа нарын өвөл, зуны тусгай хувцас, таних тэмдгийг 37,569.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч бараа материалын дансанд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан нь УСНББОУС-12 "Бараа материал", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

тул санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын дансанд бүртгүүлж залруулав.

3. Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/33 дугаар тушаалаар 51,073.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлж бүртгээгүй, элэгдлийн зардлыг бүртгэлд тусгаагүй нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "Ангилал" батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлаар бүртгүүлж залруулав.

Мөн аудитаар нийт 1,554.1 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,554.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 22,158.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

- Албан хаагчдад онцгой нөхцөлийн нэмэгдэл, ажилласан өдөрт ногдох цалинг 1,502.1 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын даргын 2024 оны Б/91, Б/98 дугаар тушаалтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоож, зөрчлийг аудитын явцад барагдуулсан.

### 5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлагналтай холбоотой албан шаардлага өгөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь суутган тооцсон ХХОАТ-ын 117,626.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байхад цалингийн сангаас 15,228.5 мянган төгрөгийг ахмадын сангийн дансанд шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Цалингийн зардалтай холбоотой өр, авлагыг тухай бүр холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулж, өр төлбөрийг барагдуулж байх

##### 1.2 Илрүүлэлт:

Тус байгууллага нь газрын даргын 2024 оны Б/42 дугаар тушаалаар тус байгууллагын ахмад ажилтнуудын холбооны тэргүүн, гүйцэтгэх захирал нарт 6,930.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "ахмадын сан" гэж ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын төсөв, үйл ажиллагааны орлогоос хуульд заасан хувь, хэмжээгээр тооцож бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг", 14 дүгээр зүйлийн 14.6, Засгийн газрын 2017 оны 197 дүгээр тогтоолоор

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 2 дугаар хавсралттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хууль болон холбогдох журамд нийцүүлж зарцуулж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасны дагуу ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> 20.5. Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шатахуун худалдах, худалдан авах гэрээнд заасанд 1,593.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийн урамшууллыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй	1	1,593.9	1	1,593.9	-	-	1	1,593.9	-	-	-	-
Олон нийтийн цагдаа нарын өвөл, зуны тусгай хувцас, таних тэмдгийн 37,569.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч бараа материалын дансанд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан	1	37,569.0	1	37,569.0	-	-	1	37,569.0	-	-	-	-
Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/33 дугаар тушаалаар 51,073.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлж бүртгээгүй, элэгдлийн зардлыг бүртгэлд тусгаагүй	1	51,073.6	1	51,073.6	-	-	1	51,073.6	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>90,236.5</b>	<b>3</b>	<b>90,236.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>90,236.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан хаагчдад онцгой нөхцөлийн нэмэгдэл, ажилласан өдөрт ногдох цалинг нийт 1,502.1 мянган төгрөгөөр илүү олгосон	1	1,502.1	1	1,502.1	-	-	-	-	-	-	-	-
Тус байгууллага нь суутган тооцсон ХХОАТ-ын 117,626.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байхад	1	15,228.5	-	-	-	-	1	15,228.5	-	-	-	-

